

БидиСЕК ҮЦК ХК, Залуучуудын өргөн чөлөө 27/1,
8-р хороо, Сүхбаатар Дүүрэг, Улаанбаатар хот, МУ
Утас: (976) 7555 1919, И-мэйл: info@bdsec.mn

www.bdsec.mn

Өдөр 2023.11.29 Тоот 23/370

Анхдагч зах зээлийн арилжааны мэдэгдэл хүргүүлэх тухай

Андеррайтер “БидиСЕК ҮЦК” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 сарын 13-ны өдрийн 206 тоот тогтоолоор бүртгэсэн үнэт цаас гаргагч “ХААН Банк” ХК-ийн Ногоон бондын хөтөлбөр (цаашид “Ногоон бондын хөтөлбөр” гэх)-ийн хүрээнд нийтэд санал болгох ногоон бондын анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” (цаашид “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” гэх)-ын 6.5 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Ногоон бондын танилцуулгад тусгасны дагуу Ногоон бондын хөтөлбөрийн эхний үе шатанд төгрөгийн бондыг дараах нөхцөлөөр нийтэд санал болгохоор “ХААН Банк” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/394 тоот тушаалаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. Бондын үндсэн нөхцөл

Татан төвлөрүүлэх дүн (төгрөг)	17,000,000,000
Нийт тоо, ширхэг	170,000
Бондын нэрлэсэн үнэ (төгрөг)	100,000
Бондын хүү	16 %
Бондын хугацаа	3 жил
Хүү (купон) төлөх нөхцөл	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх нөхцөл	Хугацааны эцэст

2. Үнэт цаасыг танилцуулах, санал болгох ажиллагаа

Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь хөтөлбөрийн эхний үе шатанд санал болгох ногоон бондыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг 2023 оны 12 сарын 06-ны өдрөөс 12 сарын 08-ны өдрийн хооронд зохион байгуулна.

Ногоон бондын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 12 сарын 11-ний өдөр 10:00-17:00 цаг, 12 сарын 12-ны өдөр 09:00-17:00 цагийн хооронд хүлээн авах ба хөрөнгө оруулагчдын ирүүлсэн захиалгыг цаг хугацааны дарааллаар бүртгэн,

захиалгын сан бүрэн бүрдсэн тохиолдолд захиалга хүлээн авах ажиллагаа дуусгавар болно.

Анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулах төлөвлөгөө

	2023.12.06	2023.12.07	2023.12.08	2023.12.09	2023.12.10	2023.12.11	2023.12.12
Нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулах							
Захиалга хүлээн авах							


Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Үнэт цаас гаргагчтай хөрөнгө оруулагчдыг төлөөлж Андеррайтерын байгуулсан “Бондын гэрээ”-ний 6.8 дахь хэсэг, Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 4.4 дэх хэсэг болон Ногоон бондын хөтөлбөрийн танилцуулгад тус тус тусгаснаар стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох ам.долларын бондын нөхцөл, ам. долларын бонд эзэмшигчдийн зарим эрх, үүрэг нь төгрөгийн бондын эзэмшигчдээс ялгаатай болохыг нийт хөрөнгө оруулагчид анхаарна уу. Уг нөхцөл, эрх, үүргийг илүү ойлгомжтой болгох үүднээс шаардлагатай тохиолдолд Ногоон бондын хөтөлбөрийн танилцуулга болон “Бондын гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулж, Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд заасан зохих ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох хүсэлтийг ам.долларын бондыг олон нийтэд санал болгохоос өмнө эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх болно.

Үнэт цаас гаргагч нь Ногоон бондын хөтөлбөрийн дараагийн үе шатуудад нийтэд санал болгох ногоон бондын нөхцөлүүдийг тухай бүр тодорхойлж, Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 6.5 дахь хэсэгт заасан анхдагч зах зээлийн арилжааны мэдэгдэлд тусган, нийтэд мэдээлнэ.

Иймд та бүхэн дээрх хуваарийн дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж өгнө үү.

Хавсралт: “ХААН Банк” ХК-ийн гүйцэтгэх захирлын 01/394 тоот тушаал

Хавсралтын хуудасны тоо: 2



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ХААН БАНК

ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 01/394

Улаанбаатар хот

Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, ХААН Банк ХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 30 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 06 сарын 13-ны өдрийн 206 тоот тогтоолоор бүртгэсэн үнэт цаас гаргагч ХААН Банк ХК-ийн Ногоон бондын хөтөлбөр (цаашид “Ногоон бондын хөтөлбөр” гэх)-ийн хүрээнд төгрөгөөр гаргах ногоон бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.

2. Ногоон бондын хөтөлбөрийн хүрээнд эхний үе шатанд төгрөгийн бондыг дараах нөхцөлөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсүгэй. Тодруулбал:

Бондын үндсэн нөхцөл

Татан төвлөрүүлэх дүн (төгрөг)	17,000,000,000
Нийт тоо, ширхэг	170,000
Бондын нэрлэсэн үнэ (төгрөг)	100,000
Бондын хүү	16 %
Бондын хугацаа	3 жил
Хүү (купон) төлөх нөхцөл	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх нөхцөл	Хугацааны эцэст

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” (цаашид “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” гэх)-ын 3.6 дахь заалтыг үндэслэн Үнэт цаас гаргагчтай хөрөнгө оруулагчдыг төлөөлж Андеррайтерын байгуулсан “Бондын гэрээ”-ний 6.8 дахь хэсэг, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 4.4 дэх заалт болон Ногоон бондын танилцуулгад тус тус тусгаснаар стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох ам.долларын бондын нөхцөл,

бонд эзэмшигчдийн зарим эрх, үүрэг нь төгрөгийн бондын эзэмшигчдээс ялгаатай болохыг Андеррайтер “БиДиСек ҮЦК” ХК-тай хамтран Монгол улсын холбогдох хууль, журмын хүрээнд нийтэд мэдэгдсүгэй.

4. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч /Б.Эрдэнэдэлгэр/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хувийг Ерөнхий аудитор /Д.Дугарбаатар/-т хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын ажлын алба /О.Энхмаа/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.МӨНХТУЯА